

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар

422

Арвайхээр

Коронавируст халдварын (КОВИД)-19-ын эсрэг
вакцины нэмэлт тунгаар вакцинжуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины нэмэлт тунгаар вакцинжуулах тухай” А/539 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлааны түвшинг нэмэгдүүлэх зорилгоор 55-аас дээш насны иргэд, боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээ хийлгэсэн, хавдартай, ХДХВ, гепатитын В,С вирусийн архаг халдвартай, дархлаа дарангуйлах, гемодиализ эмчилгээнд хамрагддаг зэрэг эрсдэлт бүлгийн иргэн, хөхүүл, жирэмсэн үедээ вакцинд хамрагдсан эмэгтэй, коронавируст халдвар (КОВИД-19)-ын хариу арга хэмжээний багийн гишүүд болон хүндэтгэх шалтгаантай иргэдийг сайн дурын үндсэн дээр коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины нэмэлт нэг тунгаар вакцинжуулах ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины хоёр тунд бүрэн хамрагдсан, хоёр дахь тунг тарьснаас хойш гурван сар өнгөрсөн байх шалгуурт нийцэх иргэнийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг Пфайзер үйлдвэрийн “Комирнэти”, Синофарм/ВІВР үйлдвэрийн “СоrV” вакцинаас сонголт хийлгэн, дархлаа сэргээх тунгаар вакцинжуулсугай.

3. Нэмэлт тунгаар вакцинжуулахад шаардагдах Пфайзер үйлдвэрийн “Комирнэти”, Синофарм/ВІВР үйлдвэрийн “СоrV” вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг хавсралтаар баталсугай.


4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтад хамрагдаагүй эсхүл вакцины нэг тунг хийлгэсний дараа коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилсөн иргэнд эдгэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дараа тухайн вакцинаар дархлаажуулсугай.

5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины нэмэлт тунгаар вакцинжуулах арга хэмжээг зохион байгуулах, мэргэжлийн удирдлаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (М.Золзаяа), вакцинжуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, цэгийн тоог нэмэгдүүлэх, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын


13369-61

хэрэгжилтийг чанд мөрдөн ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун), Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, ерхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, вакцинжуулсан хүн амыг бүртгэх, дархлаажуулалтын цахим бүртгэлийн программын хэвийн үйл ажиллагааг ханган, вакцин, дархлаажуулалтын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 09 сарын 01 ны өдрийн №... дугаар тушаалын хавсралт



ПФАЙЗЕР ҮЙЛДВЭРИЙН "КОМИРНЭТИ", СИНОФАРМ/ВІВР ҮЙЛДВЭРИЙН "СОРV" ВАКЦИН, ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

№	Сум, өрхийн нэр	Хамрагдвал зохих хүний тоо	Вакцин		Тариур		Аюулгүй хайрцаг
			Нийт тун	флакон	0.3 мл (ширхэг)	3 мл (ширхэг)	
1	БаруунБаян-Улаан	204	204	34	204	34	2
2	Бат-Өлзий	396	396	66	396	66	3
3	Баянгол	228	228	38	228	38	2
4	Баян-Өндөр	276	276	46	276	46	3
5	Богд	306	306	51	306	51	3
6	Бүрд	198	198	33	198	33	2
7	Гучин-Ус	132	132	22	132	22	2
8	Зүйл	204	204	34	204	34	2
9	ЗБУ	252	252	42	252	42	2
10	Нарийнтээл	252	252	42	252	42	2
11	Өлзийт	180	180	30	180	30	2
12	Сант	234	234	39	234	39	2
13	Тарагт	222	222	37	222	37	2
14	Төгрөг	150	150	25	150	25	2
15	Уянга	492	492	82	492	82	4
16	Хайрхандулаан	204	204	34	204	34	2
17	Хархорин	960	960	160	960	160	8
18	Хужирт	504	504	84	504	84	4
19	Нарны дөш	708	708	118	708	118	6
20	Уянсэтгэл	612	612	102	612	102	5
21	Түшигдөлгөөн	876	876	146	876	146	7
22	БОЭТ	198	198	33	198	33	2
	Нийт	7788	7788	1298	9086	1298	69